ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ: МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-2021

Б.БАЯРДАВАА
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
МОНГОЛБАНК

2020 оны 10 дугаар сарын 9

Улаанбаатар хот

АГУУЛГА

I. УИХ-ын тогтоолын төсөл /Бусад байгууллагатай хамтрах/

II. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл /Монголбанк/

III. Төслийн тооцоо судалгаа: Эдийн засгийн төлөв

I. УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай...

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай...

1/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Монгол Улсын үнэлгээг сайжруулах, холбогдох зөвлөмжтэй нийцүүлэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх;

2/ Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

3/ Санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах;

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай...

4/ Банкны салбарын актив хөрөнгийг ангилж, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын шилдэг туршлага, зөвлөмж, Монгол Улсын банкны салбарын онцлогт тулгуурлан боловсронгуй болгож, үе шаттайгаар мөрдүүлэх;

5/ Банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэх;

6/ Олон улсын сайн туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;

7/ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах;

II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

1.1. Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2021-2023 онд **+/-2** нэгж хувийн интервалтай **6** хувийн орчимд тогтворжуулна.

1.2. Банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Төв банкны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах зорилгоор олон нийтийг мэдээллээр хангаж ажиллана.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд

2.1. Санхүүгийн мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарт учирч болзошгүй сөрөг нөлөөг бууруулж, банкны эрсдэл даах чадварыг хадгална.

2.2. Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн сайжруулж, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчинг боловсронгуй болгоно.

2.3. Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах зорилгоор хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

3. Санхүүгийн захын дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд

3.1. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.

3.3. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

III. ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Инфляцын дарамт бага байна...





- Инфляц улсын хэмжээнд 2020 оны 8 дугаар сард 2.1 хувь, Улаанбаатар хотод 1.7 хувьд байв.
- КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил огцом суларч, эрэлтийн шалтгаантай инфляц энэ онд бага байна.
- 2021 онд эдийн засгийн өсөлт сэргэж, эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэн Төв банкны инфляцын зорилтын орчимд тогтворжих хүлээлттэй байна.

Эдийн засгийн сэргэлт инфляцын дарамтыг нэмэгдүүлэхгүй, гадаад орчин инфляцын хэлбэлзлийг голлон тайлбарлана...



Эдийн засаг 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшлаа...



Эдийн засаг энэ оны эхний хагаст огцом буурахад:

- Уул уурхай -29.4% (-6.2%)
- Уул уурхайн бус -4.4% (-3.5%)
- Хөдөө аж ахуй +13.2% (+1.9%)
- Боловсруулах -5.2% (-0.3%)
- Эрчим хүч +2.9% (+0.1%)
- Барилга -6.2% (-0.2%)
- Худалдаа -13.4% (-1.5%)
- Тээвэр -32.7% (-1.8%)
- Мэдээлэл холбоо +0.3% (0%)
- Үйлчилгээ -0.2% (-0.1%)
- Бүт цэвэр татвар -11.9% (-1.6%)

Уул уурхайн салбар 3-р улирлаас сэргэх төлөвтэй байна...



Уул уурхайн салбарын голлох 5 бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс **5.4 хувиар** агшсан. Энэ нь 2020 оны 1 болон 2 дугаар улирлаас сайжирсан үзүүлэлт бөгөөд үүнд дараах бүтээгдэхүүний үйлдвэрлэл голлон нөлөөллөө:

- Нүүрс -10.8 нэгж хувь (-42.9%)
- Төмрийн хүдэр -1.5 нэгж хувь (-17.3%)
- Газрын тос нөлөөгүй буюу 0% (+0.0%)
- Зэсийн баяжмал +2.8 нэгж хувь (+8.4%)
- Алт +3.7 нэгж хувь (+24.7%)

Бодит эдийн засаг 2020 онд агших боловч сэргэлт сүүлийн хагасаас эхэлнэ...

Эдийн засгийн өсөлт, 4 улирлын нийлбэрээр





- КОВИД-19 вирусын эдийн засагт үзүүлж буй нөлөө хүлээлтээс давж, үргэлжлэх хугацаа сунжирч байна.
- Түүхий эдийн үнэ, гадаад, дотоод эдийн засгийн орчин хүлээлтээс муудвал хямрал төсөөллөөс гүнзгийрэх эрсдэлтэй.
- Ирэх онд гадаад эрэлт сэргэх, Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж сайжирч, уул уурхайн салбар идэвхжих зэрэг нь эдийн засгийн өсөлтөд өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байна.

Ирэх онд эрэлт сэргэх хүлээлттэй байна...



Мөнгөний үзүүлэлтүүд сул байна...





Эх үүсвэрийн долларжилт өндөр байна...





*Тэтгэврийн зээлийн тэглэсэн нөлөөг засварласан

Төсвийн орлого тодотгосон дүнгээс нэмж тасрах эрсдэлтэй...

тэрбум төгрөг	2019	2020		2019.07	2020.07		2020.7/ 2019.7
	Гүй.	Тод.	Төс.*	Гүй.	Гүй.	Гүй %	Хувь
Нийт орлого	**11937**	**10729**	**10510**	**6786**	**5262**	**77.8**	**77.5**
Ирээдүйн өв сан	1040	943	817	714	345	75.3	48.2
Тогтворжуулалтын сан	95	55	179	37	17	24.2	45.9
Тэнцвэржүүлсэн орлого	**10802**	**9731**	**9513**	**6035**	**4900**	**78.6**	**81.2**
Татварын орлого	9749	8847	8564	5485	4496	80.6	82.0
Татварын бус орлого	1053	884	868	550	405	61.3	73.6
Нийт зардал	**11429**	**14577**	**14217**	**5500**	**7366**	**83.9**	**133.9**
Анхдагч зардал	10568	13605	13325	5038	6907	83.6	137.1
Урсгал зардал /-хүүний зардал/	7347	10178	10111	4056	5394	88.5	133.0
Хөрөнгийн зардал	2818	3408	3198	868	1482	72.0	170.7
Цэвэр зээл	403	19	15	114	31	28.6	27.6
Хүүний зардал	861	973	892	462	459	88.9	99.4
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	**-628**	**-4847**	**-4703**	**535**	**-2466**		
Нийт тэнцэл	**508**	**-3848**	**-3707**	**1286**	**-2104**		
ДНБ-д эзлэх хувь	-1.7%	-12.5%	-12.5%				
Анхдагч тэнцэл	233	-3874	-3811	997	-2006		
ДНБ-д эзлэх хувь	0.6%	-10.0%	-10.2%				

**-Монголбанкны төсөөлөл*



Төлбөрийн тэнцэл 2020 онд 540 сая $-ын алдагдалтай боловч гадаад валютын нөөц 7-8 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байна.

Төлбөрийн тэнцлийн төсөөлөл

Урсгал тэнцлийн төсөөлөл



Экспортын үнийн төсөөлөл болон гүйцэтгэл сүүлийн улиралд сайжирлаа.

Голлох эдийн засгуудын өсөлтийн төлөв

		2020*	2021*
БНХАУ	Өмнөх	1.6	8.0
	Одоо	1.6	8.2
АНУ	Өмнөх	-3.9	4.3
	Одоо	-5.9	4.3
ОХУ	Өмнөх	-4.4	2.5
	Одоо	-5.1	2.9
Евро бүс	Өмнөх	-5.0	3.0
	Одоо	-8.7	5.9

Эх сурвалж: Bloomberg, Roubini Global Economics, The EIU
Гадаад эрэлтийн тооцоонд БНХАУ 90%, Евро бүс 8%, ОХУ 2%

Экспортын үнийн төсөөлөл, жилийн дундаж

Экспорт	нэгж	Төсөөлөл	Жилийн дундаж үнэ 2019	2020	2021
Нүүрс /хилийн үнэ/	$/тонн	Одоо	79	67	60
		Өмнөх	79	61	63
Зэс	$/тонн	Одоо	6009	5803	6128
		Өмнөх	6009	5258	5209
Алт	$/унц	Одоо	1402	1839	1828
		Өмнөх	1402	1660	1688
Түүхий нефть	$/бар	Одоо	65	41	45
		Өмнөх	65	37	38
Төмрийн хүдэр	$/тонн	Одоо	90	88	76
		Өмнөх	90	85	80

Эх сурвалж: Bloomberg, Roubini Global Economics, The IMF, World bank, BREE

Дэлхийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байна.

Google mobility index



Дэлхийн PMI индекс



Oxford stringency index



Дэлхийн худалдааны сарын өөрчлөлт



Эдийн засгийн идэвхжлийг илэрхийлэх үзүүлэлтүүдээс харахад:

- Хөгжингүй орнуудад хөл хорио суларч байна.
- Хөгжингүй орнуудын иргэдийн хөл хөдөлгөөн нэмэгдэж байна.
- Дэлхийн аж үйлдвэрлэл болон үйлчилгээний PMI индекс сэргэж байна.
- Дэлхийн худалдааны эргэлт энэ оны 6-р сараас эерэг өсөлттэй болов.

Энэ онд гадаад орчин ханш сулрах гол хүчин зүйл болж байна.



Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэвэл: Гутранги байдал буурсан, тодорхой бус байдал өндөр хэвээр

- **Эдийн засгийн 2020 идэвхжил хүлээлтээс сул байна.**
  - 2021 оноос эерэг итгэл давамгайлж байгаа боловч хямралын суурь шалтгааны тодорхой бус байдлаас хамаарч байна.
  - Төсөөллийн тодорхой бус байдал өндөр байна.
  - Инфляц нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна /Нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлээс их хамаарна/.
  - Ковид-19 вирусын эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэж, үргэлжлэх хугацаа нь сунжирч байна.
  - Уул уурхайн салбар 3-р улирлаас сэргэхээр тооцов.
- **Санхүүгийн зах зээлд эрсдэл өндөр байна.**
  - Эх үүсвэрийн долларжилт өндөр байна.
  - Харин зээлийн долларжилт маш бага
  - ААН-ийн хугацаа хэтэрсэн зээл нэмэгдэж байна.
- **Гадаад орчны тодорхой бус байдал өндөр байна.**
  - Ковид-19 үргэлжлэх хугацаа, гадаад, дотоод эдийн засагт үзүүлэх нөлөө тодорхойгүй хэвээр байна.
  - Вакцин гарах хугацаа, түүний хүрэлцээ тодорхойгүй байна.
  - Ирэх оны эхний хагаст цар тахал хяналтад орохгүй тохиолдолд эдийн засгийн үзүүлэлтүүд 2021 онд төсөөлөлд хүрч сайжрахгүй.
  - Гадаад тэнцвэрт бус байдал өндөр байна.
  - Урсгал тэнцлийн алдагдал өндөр тул гадаад тэнцэл зээл, тусламжаас их хамааралтай байна.
- **Эдийн засагт эрсдэл хуримтлагдаж байгаа тул зээлжих зэрэглэл буурах эрсдэлтэй байна.**
- **Төсвийн болон мөнгөний бодлогын цаашдын орон зай нь валютын урсгалаас шууд хамаарна.**

Монголбанк

Анхаарал хандуулсанд баярлалаа

Монголбанк
Бага тойруу-3, 15160 Улаанбаатар 46, Монгол улс
http://www.mongolbank.mn